ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

ДАГУУР УГСААТНЫ ЭРТ, ЭДҮГЭЭГИЙН БАЙДАЛ

Ж. Өлзий

Дагуурын гарал үүсэл. Түүхэн домог ёсоор Кидан улсын өвөг дээдэс болох Чишанханы 8 хүүхдийн хойч үеийн үр ач нар нь улам өссөөр 8 аймагт хуваагджээ. Эдгээр 8 хүүхэд нь Ляахэ хэмээх Шар мөрний баруун тал Түхэ (Шороотны голын) хойд талаар нутаглаж байжээ. Энэ 8 хүүхдийн нэгийг дагуур (да-хэ[1]) гэж нэрлэдэг байжээ.

Хятадын Лү-Ша, Жи-Лү гэдэг номонд дагуур бол Юан улсын үеийн цэргээс үлдсэн ард мөн гэжээ. Түүнчлэн дагуур бол газарзүй, үг яриа, шашин шүтлэг, зан суртахууны талаар Тан улсын үеийн Татар болон Юан улсын үеийн Татарын үлдэгдэл аймаг мөн гэсэн зүйл байдаг.

Гэвч дагуурын Мэрсэ-гийн бичсэн ‹‹Хөлөн-Буйрын ард олонд ятган сануулах бичиг››-тээ дагуур угсаатан бол эртний үеийн хуучин Монголын үлдэгдэл мөн[2] гэж бичсэн байна. Мөн Дагуурын Алтанхад хэмээх зохиогч ‹‹Дагуур Монголын судлал››, ЗХУ-ын эрдэмтэн Б. Я. Владимирцов ‹‹Монголын нийгмийн байгууллын түүх›› гэдэг номнууддаа Татарын хойд үе гэх буюу дагуурын үг хэл, зан заншил, аж амьдрал зэрэг монгол үндэстэнтэй цөм нэгэн адил тул монгол гаралтай гэж тус тус бичсэнээс гадна Дагуурын ард түмэн, эрдэмтэд ч Дагуур бол монгол гаралтай монгол хүн гэж хэлээд, дээр үеэс эхлэн монгол үндэстнээ ихээр мөрөөдөн ярьцгаадаг уламжлалтай юм. Зарим эрдэмтэд Дагуурыг Солон, Орчоон, Манж-Түнгүс үндэстний салбар ястан гэдэг явдал ч бас бий. Энэ нь Дагуурчууд ХҮП зууны эхэн үед Амар мөрөн (Хар мөрөн)-ий эрэг, Нууц мөрөн, Цицихар (хязгаар), Морин-даваа, Жалан-Айл (Жалан-Түн) зэрэг газруудаар дээрх угсаатнуудын хамт холилдон он удаан жил нутаглаж ирсний харгайгаар голдуу Түнгүс гаралтай хэмээн судалгааны дүнгээр буруу бичсэн байдаг гэж Алтанхад номондоо шүүмжлэлтэйгээр тэмдэглэсэн нь үнэний талтай зүйл юм.

Дагуурын овог нэрийн тухай. Дагуурын Хэйн-Жэхир, Валай-Говол, Бутган зэрэг овогтны олонхи нь Цицихар нутагт Бутган дагуур Жалантүн зэрэг газруудад оршин суудаг байжээ.[3] Мөн ХҮШ зууны дунд үеэс эхлэн нутаг дэвсгэрээр Цицихар (Бөөхүй) орчмыг Цицихар дагуур, Нуун мөрний орчмыг бутхан (гөрөөчин) дагуур, Хайлар орчмыг Хайлар дагуур гэж тус тус нэрлэх болсон юм.

1732 оны үед Бутханаас 730 хүнийг Хөлөн-Буйрын газарт нүүлгэн авчирсны дотор Говол, Мэрдэн, Уул зэрэг гурван овгийн хүн одоогийн

1. Тогтох, «Ляо улсын түүх», 32-р бүлэг, 4-5-р тал. (Хятад хэл дээр)

2. Мэрсэ, «Хөлөн-Буйрын ард түмэнд ятган сануулах бичиг», 1928 он. 13-р тал.

3. Хэцютао, «Умарт зүгийн тэмдэглэл» (Бадруут төрийн орнуудад хэвлэв). (Хятад хэл дээр), I боть, 7-р талд.

Хөлөн-Буйр аймгийн Эвенк ястны өөртөө засах хошууны Баянцагаан сум, Баянтохой сум болон өмнө айл, баруун айл, Мэхээрт зэрэг газруудад оршин сууж[4] 200 гаруй жил болжээ.

Дагуурын газар нутгийн тухай. Дагуур бол эртний Кидан ба Татарын хойч үе нь мөн учир Монголын Юан улсын үед одоогийн байгаагаас нэлээд байруун хойгуур нутагладаг Түмэт цэргийн үлдэгдэл ардууд байгаад ХҮП зууны эхэн үеэр Хар мөрнөөр дамжин Манжийн хааны эрхшээлээр Нуун мөрний сав газарт нүүн очиж сууурьшжээ. Ингээд Хар мөрөн, их хянган нурууны уулархаг сайхан үзэсгэлэнтэй, ой мод ихтэй тайга газрыг үндсэн нутаг орноо болгон[5] тогтнон суурьшсан байна. Дээр үед дагуур бол Хар мөрний урсгал дагуу баруун, зүүн хоёр хэсэгт хуваагдан өөрийн эрхээр амьдарч байсан боловч сүүлийн үед Хятадын Хар мөрний жанжны харьяат мужийн хязгаар дотор чанга хязгаарлагдаж, тэрхүү мужийн төв Цицихар хот, мөн Жалан-Түн, Морин-даваа, Нуун мөрний баруун тал, Сунгаар мөрний зүүн талаар төвлөрөн суурьшжээ. Одоо үед тэд л Хөх мөрөн муж, баргын Хайлар хот хоёрын хооронд оршин суугцгааж байна.[6]

Орчин үед Дагуурчууд голдуу БНХАУ-ын Хар мөрөн мужийн олон хятад сянь болон Өвөр Монголын район, Синьцзян—Уйгарын нутагт тархай бутархай суурьшин нутаглаж, ихэнх хувь нь Хятадын аж амьдралын заншил хэвшилд ороод байна. Одоогийн дагуурчуудын нутагладаг Хар мөрөн мужийн хятад сяниуд гэвэл Лүнцзян сянь Пүюнсянь (Буянт сянь), Нэхэсянь (Нуун гол сянь), Айхун сянь зэрэг болохоос гадна мөн Хар мөрөн мужийн төв Цицихар хотод дагуур хүмүүс нэлээд олон сууж хятад хүнээс бараг ялгагдахгүй болжээ.

Мөн Синьцзяны өөртөө засах орны баруун хойд хязгаарын Тарвагатай уулын хормой болох Гурван шээр зэрэг газарт дагуур нар цөөнгүй сууж байна.

Өвөр Монголын өөртөө засах орны Морин-Даваа хошуу, Бутган хошуу (Жалан-Түн), Хөлөн-Буйр аймгийн Эвенк хошуу, Наньтүн, Хага, Жалмат зэрэг манжуур-Харбины төмөр замын дагуу дагуур нар сууж байна.

Эдгээр газрын дагуур хүмүүс ерөнхийдөө 50 мянга орчим байна гэж зарим зохиогчид бичжээ.[7] 1957 оны Хятадын хүн амын бүртгэлээс Дагуур хүн 44 мянга орчим байсан байна.

Дагуурын цэрэг, засаг захиргааны зохион байгуулалтын тухай. Манжийн Энх-Амгалан хааны 28-р он (1689 он)-д Солон, дагуурыг Манжийн цэргийн 8 тугийн (8 хошууны) зохион байгуулалтанд оруулж, Бутган нутгийн Анчин аймгийн 8 хошуу гэж нэрлэжээ.[8] Мөн Нуун мөрний орчим Цицихар бутган дагуурыг манж нар 8 хошууны зохион байгуулалтанд оруулж 39 сум, 3 хошуу болгон зохион байгуулжээ. Эдгээр хошуунаас Хар мөрний мужийн цэрэгт элссэн нэгэн хэсгийг 8 айл буюу 8 хороо гэж нэрлэжээ.[8]

ХҮП зууны эхний хагаст Манж нар олон угсаатан, ястан нарыг өөрийн ноёрхолд түрэмгийлэн эзэлж, манж үндэстнийг бэхжүүлэхийн

4. «Хөлөн-Буйрын товч тэмдэглэл», 193—194-р тал. 1924 он. Шанхай (хятад хэл дээр)

5. Онон Өргөнгөө, «Бидний залуу үеийн Монгол», Токио. 1976 он. 1-2-р тал. (Япон хэлээр)

6. Манж—Монгол бүрэн бичиг. 1-р боть. Дайрэн, 1921 он. 501 — 502-р тал. (япон хэлээр)

7. Ванжүнной, «Чин улсын түүхийн эмхтгэл», Бээжин, 1957 он. 99—100-р тал. (Хятад хэл дээр).

8. Манж-монгол бүрэн бичиг. 1-р боть. 1921 он. Тайрэн хот. 501—502-р тал (япон хэл дээр)

тулд удаан хугацаагаар ойр дотно байсан дагуур, Солон аймгаас Манжийн цэрэгт олон тоогоор элсүүлж дайн байлдаанд оруулж байжээ. ХҮП зууны сүүлчийн хагаст дагуур, Солон гэх нэр нэлээн тодорхой гарч ирсэн түүхтэй. Ер нь Манж Чин улсын цэрэгт Дагуур, Солон, Орчоон, Балаар зэрэг угсаатан, ястны хүмүүс дайчлагдаж байжээ. Найралт төвийн 10-р он (1732 он)-д Хөлөн-Буйрын газарт 3 мянган цэргийг 50 сум болгон суулгаж, цэргийн захирагч нэгийг томилж бүгдийн дарга, занги, орлон хөгөөгч зэрэг ноёд түшмэдийг бас томилон суулгаснаас гадна Манжийн засгийн газраас Найралт төвийн онуудад дотоод сайд Дабахай, Борвин нарыг илгээн явуулж, Хөлөн-Буйрын газар орныг шалгуулжээ. Үүнд Орчоон 359, Солон 1636, Дагуур 730, Чивчин барга 375, хөгширсөн өвчин эмгэгтэй 796 хүнийг нүүлгэн ирүүлж, манжийн цэргийн 8 хошуу болгон зохион байгуулжээ.

Тэдгээрийн дотроос Зүүн гарын 4 хошуунд Оростой хил залгаа газрыг хамгаалах, баруун гарын 4 хошуунд Халхтай хил залгаа газрыг хамгаалах үүрэг тушаалыг тус тусад нь өгч, айл өрхөөр нь хоёр улсын хилийн дагуу нутаглуулжээ.

Хот суурин барих, тариа тарих ажлыг хойшлуулж, адуу 24100, хонь, ямаа 20000, цэрэг бүрд гүү 5, үнээ 3, хонь 30 толгойг цэргийн зэвсэг, цалин мөнгөний хамт олгож, шинэ бэлчээр газрыг ашиглуулсан байна.[9]

Тэрхүү цэргийн учраар Цицихар, Бутганы газраас нүүж ирсэн Дагуур хүмүүсээс— Хөлөн Буйрын газар хүйтэн бөгөөд элсэрхэг хөрстэй болохоор тариалангийн аж ахуйд үл тохирох тул Бутган нутагтаа буцах тухай өргөдлийг удаа дараа гаргасан учир Хар мөрөн мужийн жанжин Бүдээс тэнгэрийг тэтгэсний 7-р он (1742)-д Дагуурын 24 сумын цэрэг дарга нарын хүссэний ёсоор Манжийн хаанд гуйн айлтгаж, тэдгээрийг уул Бутган дагуурын нутагт нь буцаан нүүлгэсэн байна.[10]

1732 онд Манжийн хааны зааврaар Хөлөн-Буйрын газарт нүүж ирсэн дагуур нь Солон баргийн (Чивчин барга) ард түмэн Манж-найман хошууны ‹‹хууль дүрмийг танилцуулан›› албан хэрэг шийтгэх ёс журмыг ‹‹заан сургахаар›› томилогдон ирсэн хүмүүс байжээ. Тэд нарыг манж нар Солон гарын бүгдийн даргын харьяанд оруулж, Хайлар хотын орчим баруун, зүүн хоёр айл байгуулан суурьшуулжээ. Дагуурын ноёд баргын төв засгийн хэрэгт оролцон, засаг, цэргийн бүх эрхийг гартаа авч,[11] бүтэн 204 жил болжээ. Энэ хугацаанд Манж Чин улсын феодал ноёдын эрх ашгийг үндэслэн баргын ард түмэнд хүнд албан татвар ноогдуулан, тэдний аж амьдралыг хүндрүүлдэг байснаас гадна баргын язгууртан, феодал ноёд, баячуудад засгийн эрх ямба, цол хэргэм, (хөх, хүрэн номин жинс, цагаан шилэн жинс, тогосны отог)-ийг олгон, тэд агт морь, амбан шар, алт мөнгөн ембүү (өлгий мөнгө)-нд худалдагдаж энгийн номхон ард олныг боолчилж байжээ. Үүний нэгэн жишээг дурдвал: Чивчин баргын түмэн адуутай 5 хошуу мал тэгш баян Жэндий занги нь хүүхэддээ сургаж хэлэхдээ ‹‹Та нар малаа сайн маллаж явагтүн! Тэрхүү язгууртан ноёдын жинс отог миний гүүний гэдсэнд байна, түүнийг худалдан авахад бэлэн

9. Ван Жүнюй. Чингийн түүврийн түүх. Бээжин 1957 он. 99—100-р (хятад хэл дээр)

10. Чин-Тун-Пү. «Дагуур үндэстний тэмдэглэлийн эх бичиг» Бээжин 1940 он. 132-134-р тал (хятад хэл дээр).

11. Эрхэмбат. «Барга аймагтны товч түүх». Хайлар хот. 1945. 10-р тал (гар бичмэл)

тул айх хэрэггүй›› гэсэн нь феодалын нийгмийн нүүр царай, баян хүн ямар эрх дархтай байсныг тод харуулж байна.

Баргын дагуурчуудын дундаас Хятад, Японы дарлал нухлалаас мултран гарахыг зорьж Баргын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө удаа дараа тэмцсээр ирсэн Хайлар, дагуурын Шэмпүү-Амбан (сайд) Цэндгүн, жич Мэрсээ, Линсин Хуалинтай (Буянгэрэл) зэрэг тэмцэгчдийг нэн түрүүн нэрлэн дурдахад болох юм.

Орчин үед Өвөр Монголын өөртөө засах оронд дагуур үндэсний өөртөө засах хошууны бэлтгэлийн комисс 1956 оны 8 дугаар сарын 25-ны өдөр албан ёсоор байгуулагдсан юм. Дагуур угсаатан нь бас Өвөр Монголын өөртөө засах оронд оршин сууж буй цөөн тоот угсаатан юм. Хүн ам нь 2 түм (20 мянга) гаруй байна. Дагуур угсаатан өнгөрсөн үед Манж Чин улс, гоминданы хятадчлал, милитарист Японы дарлал мөлжлөгийн доор удаан хугацаанд дарлагдаж байсны уршгаар өөрийн үндэсний үнэн байдлыг ойлгохгүйд хүрсэн ба түүхийн баримт ховор учраас тэд өөрсдийгөө нэгэн угсаатан мөн, эсэхээ ч нотолж чадахгүй байв.

БНХАУ-ын засгийн газар ч Өвөр Монголын засгийн газраас олон талын судалгаа, байцаалт хийж материал цуглуулж санал хураасны дүнд дагуур бол тусдаа нэгэн үндэстэн мөн болохыг нотлов гэж 1956 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Өвөр Монголын өдрийн сонин № 1324-т Түвшин гэгч хүн бичжээ. Энэ нь үндэсний түүхийг гуйвуулж, бичиж байгаа хэрэг юм. Дээр үед Кидан улс Ляо улсын түүхэнд тодорхой бичиж байгаа зүйл болон олон эрдэмтдийн бичсэн түүхийн баримтуудыг үгүйсгэн гуйвуулж, монгол үндэстний эртний нэгэн салбар болох Дагуурчуудыг ‹‹тусдаа нэгэн үндэстэн мөн хэмээн нотлов›› гэгч нь Хятад улсын үндэсний талаарх төрийн бодлого ямар байгааг бас гэрчилж байна.

Дагуурын аж амьдралын байдал. Дагуур нар бол монгол үндэстний салангид зүүн жигүүр бол байгаад XVII зууны эхэн үед Хар мөрөн (Амар мөрөн)-ний дээд урсгал дагуу үржил шимтэй нутаг бэлчээрийг сонгон нутаглаж, мал маллан, тариа тарьж ан агнах,зэргээр овог төрлөөрөө амьдарч байжээ. Улс төр, эдийн засаг, соёл боловсролын талаар төдийлөн их урагшалж хөгжөөгүй жирийн малчин ардууд байв.[12]

Дагуурчуудын зарим ардыг Манжийн Энх-Амгалан Хааны зарлигаар Хянган нурууны сахлаг сайхан ой модтой уул, тайга газрыг ан гөрөө хийх дархан цаазтай ан хийх газар болгож Манжийн ‹‹тэнгэр›› язгуртан нарыг ангийн үнэт арьс, эмийн бодис, түүхий эдээр жил тутам хангаж байх алба үүрэг ноогдуулсан учир тэд нарт гөрөөчин цол өгч ‹‹Бутган дагуур›› гэж нэрлэх болсон байна.[13] (Бутган гэдэг нь манжаар гөрөөчин анчин гэсэн үг юм).

Тэр үед дагуур газар нутагт оршин суурьшсан хятад хүмүүс ерөөсөө байгаагүй бөгөөд зөвхөн гүйлгүүр худалдаачин ирж, бараа таваар худалдан наймаалж, малын түүхий эд, ангийн үс, арсь ширээр сольж авдаг байжээ. Гэтэл орчин үед хятадын хот, сянь (хошуу)байгуулагдан, үй олон хятад хүмүүсээр дүүрч дагуур нутгийг эзэмшжээ.

Сүүлийн үед дагуурчууд мал аж ахуйгаас нэг мөсөн хагацаж, монгол гэрээ шавар байшингаар сольж хот тосгонд байнга амьдрах бо-

12. Чин Түнпү. «Дагуур үндэстний түүхийн эх бичиг» Бээжин. 1940 он, 1-2-р тал. (хятад хэл дээр)

13. Ц. Дамдинсүрэн. Дотоод Монголын байдал. Бутхан дагуур хэмээх өгүүлэлд «Шинжлэх ухаан», № 10-11. УБ 1946. 46-ртал.

лов. Малын бэлчээр нутгаа тариалангийн аж ахуйгаар сольж, эргэн тойрон атар хагалж тариа будаа тарих болжээ.

Эрт дээр үеэс тэд мориор шаламгайлан бар, чоно, хандгай зэрэг ан амьтдыг авын хүрээ тавьж бүслэн хашиж авлан ганзага дүүргэж байсан монгол удмын ан авлах мэргэн аргаа аж амьдларын нөхцөлдөө хавчигдан арга буюу орхиж, тариалан газрын явган ав зохион байгуулж, шийдэм, буултай төмөр буюу төмөр шийдмээр уурга ташуураа орлуулж, туулай, гургуул, ногтруу, оготно, зараа зэрэг жижиг амьтдыг өдөржин шөнөжин агнах болж ангийн олзгүй ирэх нь дааанч өрөвдөлтэй.

Орчин үед хүч хамтран нийлж жижиг дугуйлан байгуулаад уул хөвчөөс мод огтлон Нуун мөрөнд салаар урсган авчирч барилгын материал, гэр аж ахуйн модон эдлэл, шар дугуйтай өндөр тэрэг зэргийг хийж бэлтгээд, 500 гаруй км-ийн хол замыг тэсвэр хатуужилтайгаар туулж, барга—монголын яармаг худалдаа, аймгийн наадмын байрны Ганжуур сүмд авчиран мал, түүхий эдээр сольж, нэг жилийн амьдралын хэрэгцээгээ хангаж Бутган хошуу буюу Нуун мөрний нутаг Морин-даваа хошуундаа буцаж харьтал бараг хагас жилийн аян жин болж, хүнд хэцүү амьдарч байгаа нь үнэн ажээ.

Гэвч тэд нар тийнхүү хятад маягийн суурьшмал амьдралд шилжсэн боловч хятад хүн болохыг хүссэнгүй нь магад үнэн болно гэж зарим зохиогчид бичиж байна.[14]

Дагуурын шашин, соёл, зан суртахууны тухай. Дагуурчууд эрт дээр үеэс бөөгийн шашныг шүтсээр иржээ. Сүүлийн үед тэдний дотроос зөвхөн Хөлөн-Буйр дахь хэсэг нь буддын шашныг шүтэж[15] Хайлар хотын ‹‹өмнө айл››-ын дагуурчууд амбан сүмд мөргөл хийдэг болжээ.

Дагуур бөөгийн өмсгөл ба түүний онгон орж байгаа үеийн бөөгийн шинж байдлын тухай ярьвал: ХШ зууны үед монголчууд бөөгийн шашинд улам гүнээ орж, түүний сахиусын хүчинд итгэн шүтдэг байжээ. Тэр үеийн хүмүүс бөөгийн их сахиусын онгыг дуудвал бүх нийг аварч чадна гэдэг найдвар шингэсэн ажээ. Халдвартай буюу ерийн өвчин, түүнээс бусад байгалийн ямар нэгэн гай гамшиг болсон цагт бөө удган нар нь ард түмний зовлон зүдгүүрийг их сахиусын онгон шүтээнд даатган аврахыг гуйн хүсдэг байжээ. Монголын бөө бол Америк Индианы шидтэн бөө лугаа нэгэн адил онгыг шүтэн, элдэв увидас шид үзүүлэхийг оролддог байжээ.

Дагуур бөөгийн өмсгөл хувцас бол эртний баатрын хувцастай адилхан бөгөөд гялалзсан хөх гуулин элгэвч, ар нуруундаа хөх гуулин толь зүүж, бөөгийн цээжин биеийг халхалж, бусад биеий нь атирсан утсаар хэлхсэн хуяг шиг шар гуулин (тэр нь загасны хайрс шиг гялс гялс хийж харагддаг) олон жижиг хонхыг энд тэнд хадсан хувцас өмссөн бөөгийн онгод нь орж биеэ шилгээхэд ‹‹шар шар›› хийж шаржигнан дуугарах дуу нь сонсогддог юм. Дуулга малгайных нь оройд хүрэл зэсээр хийсэн шувуу хадаж, хоёр хажуу болон ар талдаа гялтганасан өнгө бүрийн дурдан хийсгэж чимсэн, хувцасны гол нуруунд өнгө бүрийн урт бүс хэд хэдийг унжуулан байдаг. Бөөгийн хувцсыг бүхэлд нь үзэхэд толгой нь шувуу, бие нь загас, сүүл нь тахиа шиг амьд амьтан байгаа юм шиг үзэгддэг.

14. Онон Өргөнгөө, «Бидний залуу үеийн Монгол» Токио. 1976 он. 1-2-р тал. (япон хэл дээр)

15 а) «Манж монгол бүрэн бичиг», 1-р боть. Дайрэн хот. 1921 он. 501-502-р тал. (япон хэл дээр)

15. «Енэйяма»,«Монголчууд ба монгол орон», Токио. 1943 он. 195-ртал. (япон хэл дээр)

Бөө бол зүүн гартаа хэнгэрэг, баруун гартаа арьс ширэн дохиур барьж, хэнгэргээ дэлдэж, их онгон сахиусын онгодыг дуудан залбирахдаа нэг хэсэг чимээгүй болно. Бөөгийн тахилгын хувцасны хайрсны чаран чаран гэх дуу, чир чир хийх жижиг хохны чимээ, хэнгэрэг хэцний дүн дүн гэж дуугарах дуу ширүүн сонсогдож байхад бөөгийн дуу хүнгэнэж их сахиусны онгыг аяархан дуудаж залбиран сүжиглэж, дараа нь сойвон залуу шавийн хамт бөөгийн онгоны дуудлага чанга дуудаж, бөө нь цугларсан хүний дотроос өвчин эмгэгтэй, гай барцадтай хүнийг жад сэлмээр зодоход тэдгээр хүмүүс чив чимээгүй залбиран сууцгаадаг байжээ.[16]

Орон сууцны хувьд бол дагуурчууд эрт дээр үеэс мал маллаж, нүүдлийн амьдралтай байсан учир гэрт сууж байжээ. Сүүлийн үед Нуун мөрөн, Бутган зэрэг газарт нүүж очсоны дараа хус модоор яс мод хийж гадуур нь шавраар шавж дугарга шавар гэрт сууж байгаад одоо үед шавар байшин, туйпуун байшин, шавар хэрэм хашаа барьж, тариа тарьж, суурьшлын байдалд ороод 200 гаруй жил болжээ.

Хувцас хунарын талаар манж хүний хувцастай адил хэлбэрийн хувцас өмсөөд олон жил болсон тул тэдний үндэсний хувцас мэт болжээ. Дараа нь хятад маягийн хувцас өмсөөд 100-гаад жил болжээ. Тэд бас ихэнхдээ хятад маягаар хооллож байна.

Тэд нар хэсэг хэсгээрээ хятад тариачин айлын адил айл гацаа болж суурьшин амьдарч байна. Айл дотроо ахмад хүмүүсийг айлын даргаар сонгож, тэд айлынхаа ард түмнийг удирдаж байдаг заншилтай. Тэд харь угсааны хүмүүстэй гэр бүл болдоггүй заншилтай байсан боловч сүүлийн үед хятад хүнтэй гэр бүл болох нь цөөнгүй болсон байна. Тэд эмэгтэйчүүдээрээ хүүхдээ асран бойжуулах,[17] гэрийн ажлаас өөр ажил хийлгэдэггүй байсан заншилтай. Одоо үед албан шаардлагаар тариалангийн ажил хийлгэдэг болжээ.

Дагуур хэл бол Алтай язгуурын хэлэнд багтах учир монгол, манж, түнгүс хэлний хэлбэртэй байдаг. Олонхи эрдэмтдийн үзэж байгаагаар дагуур хэлэнд YIII зууны үеийн монгол хэлний онцлог хэллэг авиа ихээхэн үлдсэн ажээ.[18]

Дагуур хэлний нутгийн гол аялага нь Бутган, Цицихар , Хайлар аялга гэж 3 салбарт хуваагдана. Үнэн хэрэгтээ бүх дагуур ястны үг хэл, зан заншил, аж ахуйн байдал их төлөв адил боловч орон нутгийн байршилтаас хамаарч бага зэрэг ялгаатай болсон байна.

Дагуурын сэхээтний дотор орчин цагийн боловсролтой, монгол, хятад хэл бичгээс гадна манж, эвеник, орос хэлийг эзэмшсэн хүмүүс цөөнгүй ажээ. Мөн цөөн тооны сэхээтэн англи, япон хэлийг мэддэг байв.

Өнгөрсөн үед дагуурчууд өөрийн үндэсний хэл монгол бичгээ зохион ном судраас гадна манж, хятад хэл дээр бичсэн ном зохиол цөөнгүй гаргаж байв. Баргын дагуур яруу найрагч Равдан ‹‹Билэгтэй илгээмж››, ‹‹Эрвээхэй дүрс›› гэдэг алдарт яруу найргийг манж хэл дээр бичсэн байна. Баргын дагуур Мэрсэ Монголын асуудлаар олон өгүүллэг товхимолыг монгол, хятадаар бичсэн байдаг. Энэ хүн латин үсгийг үндэслэн дагуурын үндэсний үсгийг зохиосон боловч түүнийг ашиглан дэлгэрүүлж чадсангүй өнгөрчээ.[19]

16. Онон Өргөнгөө, «Бидний залуу үеийн монгол» Токио. 1976 он. 29-32-р тал. (япон хэл дээр)

17. Ван Жүнюй, «Чингийн түүхийн түүвэх түүх», Бээжин. 1957 он. 99-100-р тал. (хятад хэл дээр)

18. Үндэсний судлал. Бээжин,1959 он. № 8, 105-106-р тал. (хятад хэл дээр)

19. «Дэлхийн ард түмэн угсаатны зүйн найруулагууд, дорнод Азийн үндэстнүүд» Москва, 1965 он. 72-73-р тал. (орос хэл дээр)

Дараа нь 1957 онд Өвөр Монголын өөртөө засах орны Хөх хотын олон шатны харъяа байгууллагуудын дагуур үндэстний 110 гаруй том, жижиг албан хаагч нар оролцсон хурал дээр Хөх хотын төлөөлөгч Мөнхөөгөөс ‹‹Дагуурын хэл бичгийн талаар›› илтгэл тавьж, тогтоол гарган, 23 хүний бүрэлдэхүүнтэй ‹‹Хөх хот дахь дагуур хэл бичгийн комисс›› гэдгийг байгуулж, тус комисс нь энэ талаар ойрын хугацаанд бодит арга хэмжээ авч, ажлаа зохион байгуулалттай явуулахаар тогтсон нь[20] одоо хүртэл ямарч үр дүнд хүрч чадаагүй байна.

Энэ нь дагуурчууд бол түүхийн үүднээс монгол үндэстний нэгэн салбар ястан учир өөрийн үндэстний уйгаржин монгол хэл бичгээ сурахыг эрмэлзэн, үндэснийхээ нэг онцлогийг хүндэтгэсний илрэл мөн.

ПОЛОЖЕНИЕ ДАГУУРОВ С ДРЕВНЕЙШИХ ВРЕМЕН ДО НАШИХ ДНЕЙ

(Резюме)

Согласно историческим преданиям дагууры являются потомками киданского Чишанхана. Их родовые аймаков кочевали на западном и северном берегах рек Ляахэ, Тухэ.

В китайских источниках дагууры представлены как народ, ведущий свое происхождение от воинов Юаньской армии. Но в работах дагуурского писателя Алтанхад, В. Я. Владимирцева описано гольское происхождение этого народа, как это признают сами дагууры. Существует мнение о том, что дагууры происходят от солон орчоон, манчжуро-тунгусов, но эти предположения по мнению ученых несос тоятельны. Дагууры племен хойн-жэхир, Валай-Говол, Бутган делят ся на так называемых цицикарских, бутганских, хайларских согласно их местам проживания. Дагууры племен Говол, Мэрдээн, Уул относятся к Хулунбуйрским дагуурам.

В ХУП в. дагууры селились в основном в бассейнах рек Хар мурун. Нуун мурун, в горах Хингана. В настоящее время они проживают в провинции Хар мурун, в АРВМ и СУАР КНР. Их численность сос тавляет около 44 тыс. чел. в начале ХУП в. маньчжуры, поработив многие народы, широко привлекали на военную службу своих союз ников—дагууров и солонов, доверив нм веденне караульной службы на границе. Дагууры вели справедливую борьбу против китайских и японских поработителей. Следует назвать нмена таких борцов за свободу, как Шэмпуу Амбан нз хайларских дагууров, Мэрсээ, Цэндгун, Линсин, Хуа-линтай (Буянгэрэл) и др.

В настоящее время дагууры являюстя одной из нацменьшинств Китая, проживающих в АРВМ. В последнее время дагууры, в прош лом кочевники-скотоводы, в большинстве своем ведут оседлый образ жизни, занимаясь земледелием. Дагууры, издавна исповедовали ша манизм, но среди них есть и верующие в буддизм.

20. «Өвөр Монголын өдрийн сонин», № 1441, 1957. 1. 27-ны өдөр. 1967 Ш. Нацагдорж. «Монголын феодализмын үндсэн замнал» , УБ ., 1978.

Дагуурский язык относится к алтайско-язычной группе, поэтому он близок к монгольскому, маньчжурскому, тунгусскому языкам. Различаю 3 вида диалекта (бутганский, цицикарский, хайларский). На быт и нравы дагууров оказывает большое влияние среда, в которой они живут. Среди них немало образованных людей, владеющих мно гими языками. Писатели-Дагууры публикуют немало литературных произведений на монгольском, маньчжурском, китайском языках.

В 1957 году в Хухо-хото была создана Дагуурская языковая комис сия в составе 23 человек. Это подтверждает то, что дагууры, являясь протипом монгольского народа, все еще верны своим национальном традициям.